



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
6 дугаар хороолол - 2, Ж.Самбуугийн гудамж -18,
Утас: 26-92-66, 7019-1213, Факс: (976-11) 32-50-30,
Web: www.ub.police.gov.mn,
E-mail: ubpolice@police.gov.mn

2019.03.06 № 30/1485
танай _____-ны № _____-т

Тендерийн баримт бичигт өөрчлөлт
оруулсан тухай

Таны 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Тендерийн баримт бичиг хянасан тухай” 1/296 дугаартай албан бичгийг хүлээн авч танилцлаа.

Тус цагдаагийн газраас зарлагдсан “Даатгалын үйлчилгээ”-ний тухай НЦГ/201912001 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой тайлбар, баримт материалыг цаасаар, мөн 2018 онд зарлагдсан даатгалын үйлчилгээний тендерт оролцогч компаниудын материалыг хатуу диск /CD/-ээр танай газарт хүргүүлсэн бөгөөд 2018 онд нийт 4 даатгалын компани тендерт оролцож, үүнээс 2 даатгалын компани нь тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 12.1.5-д заасан хэсгийн “... төлөөлөгч хүн сум бүрт 1-ээс доошгүй байх ...” гэсэн шаардлагыг хангасан мэдээлэл, баримт, материал ирүүлж байсан.

Гэвч тус цагдаагийн газраас зарласан “Даатгалын үйлчилгээ”-ний тухай НЦГ/201912001 дугаартай тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 12.1.5-д “Санхүүгийн зохицуулах хорооноос салбарын мэдээллийн буюу нийслэл, төв, орон нутагт санхүүгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй салбарын тоо аймаг бүрт 1-ээс доошгүй, төлөөлөгч хүн сум бүрт 1-ээс доошгүй байх тодорхойлолт болон салбарт ажиллаж байгаа ажилчид, төлөөлөгч хүмүүсийн НДШ төлсөн тухай НД-ын баталгаажсан тайлангийн хамт ирүүлнэ” гэсэн заалтаас “...төлөөлөгч хүн сум бүрт 1-ээс доошгүй...” гэснийг хасч тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж байна.

Цагдаагийн төв байгууллагаас дээрх шаардлагыг зайлшгүй байх ёстой гэж үздэг бөгөөд цагдаагийн алба хаагч нь тушаалаар түр буюу нэмэлтээр үүрэг гүйцэтгэхээр томилогдож хуульд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг аймаг, орон нутаг, сумдад хэрэгжүүлэх явцад алба хаагч нар гэмтэл, бэртэл, эрсдэлд учрах нь цөөнгүй тохиолдож, тухайн эрсдэлийг цаг алдалгүй, 72 цагийн дотор мэдэгдэх ёстой гэсэн даатгагчийн шаардлагын дагуу төлөөлөгч хүн сум бүрт 1-ээс доошгүй байх ёстой болдог. Хэрэв уг тендерт оролцогч компаниудаас төлөөлөгч хүн сум бүрт 1-ээс доошгүй байгаа тухай тодорхой мэдээлэл, судалгаа, баримт, материал ирүүлсэн тохиолдолд тендер шалгаруулалтын үнэлгээнд харгалзан үзэх нь өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг хангана гэж ойлгож байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД БӨГӨӨД
НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.ЯДАМДОРЖ



1150500569